

УРАН ЗОХИОЛЫН БИЧВЭР ДЭХ КОННОТАТИВ, ПЕРИФРАЗ УТГА, ТҮҮНИЙГ ОРЧУУЛАХ НЬ

Б.Удвал¹⁸³

Товч утга: Аливаа уран зохиол, яруу найраг бол тухайн ард түмний түүх, соёлын онцлогийг маш нарийн дүрсэлсэн бүтээлүүд юм. Дэлхийн сонгодог зохиол, яруу найраг нь хүмүүний оюун ухааны билгийн нүдийг нээж, илүү өргөн, гүн гүнзгий сэтгэдэг зөв хүнийг төлөвшүүлдэг. Харин энэ бүтээлүүдийг гадаад хэлнээс орчуулж Монголын ард түмэнд хүргэх, Монголын сонгодог сайн бүтээлүүдийг гадаад хэл рүү хөрвүүлж гадны уншигчдад хүргэнэ гэдэг орчуулагч хүний хийх ажил. Хэл соёлын ялгаатай ард түмний хэл хоорондын орчуулгыг, тэр тусмаа сонгодог болон зарим хуучирсан үг хэллэгтэй зохиол бүтээлийг орчуулах ярвигтай хэцүү ажил. Уран зохиол, яруу найрагт зохиогч нь бүтээлдээ хүч нэмж, чимэг оруулах зорилгоор коннотаци, перифраз утгыг ашиглах тохиолдол элбэг байдаг үүнийг дүйцэлтэй зөв хийхийн тулд орчуулагч эх хэлнийхээ үгсийн санг, үгийн сангийн хувиргалыг маш сайн хийдэг байх нь зүйтэй юм.

Түлхүүр үг: Коннотаци, перифраз утга, үгсийн сангийн хувиргал

1. Оршил

Коннотаци гэдэг үг нь латин хэлний *con*-буюу хамт, *noto*-буюу нэрлэх, тэмдэглэх гэсэн үгнээс гаралтай бөгөөд хэлний нэгжийн дам утга юм. Коннотаци нь нэмэлт семантик утга ба найруулгын элементийг агуулдаг. Мөн түүнчлэн прагматик мэдээлэл агуулж, юмс үзэгдлийн далд утгыг илэрхийлнэ.

Энэ ухагдахууныг сэтгэл судлалын чиглэлийн судалгаанд анх хэрэглэж улмаар логикт нэвтрүүлсэн. Харин хэл шинжлэлийн тэмдэг судлалд Данийн эрдэмтэн Louis Trolle Hjelmslev оруулсан. Үг бүхэн коннотатив утгатай байдаггүй, тухайн үндэстний хувьд онцлог зүйлс, мөн амьдралд түгээмэл тохиолддог юмс үзэгдэл коннотатив утга агуулж болно. Үгийн коннотатив утга хэд хэдэн өвөрмөц онцлогтой байдаг.

Үүнд:

- Коннотатив утга толь бичигт тэмдэглэгдэхгүй
- Коннотатив утга нь зөвхөн тухайн хэлээр яригчид, тухайн соёлд хамаарах хүмүүсийн хүрээнд ойлгогдоно.
- Коннотатив утга нь ассоциатив түвшинд дам төсөөлөл хэлбэрээр илэрнэ.
- Коннотатив утга нь цаг үеэ дагаж өөрчлөгдөн хувирдаг

¹⁸³ МУИС-ийн Завхан сургууль, ЕЭТ-ийн Англи хэлний багш

- Коннотатив утга нь олон төрлийн мэдээлэл агуулах боломжтой.

Үгийн коннотаци нь зарим тохиолдолд жинхэнэ бодит байдлаас зөрөөтэй байх нь бий. Жишээлбэл: 1980-аад оны үед Монголын нийгэмд “Тагтаа” гэдэг шувууны нэр “Энх тайван” гэдэг коннотацийг агуулж байсан бол бодит байдал дээр энэ бол манай оронд байдаг бусад шувуудын адил энгийн нэг шувууны төрөл юм. Мөн Монголын ард түмний дунд “чоно” гэдэг араатан амьтны нэрийн цаана “Тэнгэрлиг байдал, эр зориг” гэсэн коннотаци агуулдаг.

Коннотаци утгыг семиотикийн үүднээс авч үзвэл денотат утган дээр хавсран орж буй хоёрдогч утга юм. Энэхүү хоёрдогч утгыг бүрдэхэд янз бүрийн хүчин зүйл нөлөөлнө. Тухайлбал, бичгийн хэлний төрөл зүйл (яруу найрагт *дөл* гэвэл сэтгэлийн *дөл* гэх мэт) сэтгэлгээний хэвшмэл хэв маяг (*мантуу* гэвэл *хүнс* гэсэн бас *хятад* гэх коннотаци илэрдэг) нөлөөлдөг.¹⁸⁴

Англи, Америк хүмүүсийн өдөр тутмын ярианд *the cap and gown* гэхэд *graduation ceremony, student* гэх коннотаци; *my better half* гэхэд *my wife/husband/honey* гэх коннотаци агуулагдаж байдаг.

Уран зохиол, яруу найргийн бичвэрт коннотаци нь перифраз хэлбэрээр илрэх нь их. Перифраз нь юмс, үзэгдэл, үйл явцыг нэрлэсэн шууд утгаар нь бус далд утгаар өөр үг, хэлц ашиглан илэрхийлдэг найруулга зүйн нэг арга бөгөөд эртний Библи судар болон Латин хэл дээрх яруу найрагт ихээхэн дэлгэрсэн байдаг. Дундад зууны үеийн болон Европын сэргэн мандалтын үеийн зохиолч яруу найрагч нар перифраз аргаар зохиол бүтээлийнхээ уран яруу байдалд чимэг оруулж бичдэг байжээ.

Оросын эрдэмтэн Илья Романович Гальперин 1981 онд Байроны бүтээлд перифразийг хэрхэн хэрэглэсэн талаар судласан ажилдаа:¹⁸⁵

“*And Harold stands upon the place of skulls,*

The grave of France, the deadly Waterloo.”

“*The hoarse, dull drum would sleep,*

And Man be happy yet.” Энд эх бичвэр бүтнээрээ байхгүй ч дайн байлдааны тухай коннотаци утга ойлгогдож байна. Энд *hoarse, dull drum* гэсэн үгс дайн тулааныг илэрхийлсэн далд утгатай метоним гэж тайлбарласан байна. (1815 оны Waterloo-гийн дэргэдэх тулаан гэж алдаршсан Францын Наполеон хааны Прусс, Британий армид ялагдсан тулаан)

Перифразийг илрэх хэлбэрээр нь 2 хувааж үздэг¹⁸⁶

¹⁸⁴ Орчуулах эрдмийн үндэс. ХИС. 2015

¹⁸⁵ I.R Galperin Stylistics 1981 х-170

¹⁸⁶ I.R Galperin. Stylistics. 1981 х- 172

- Logical буюу учир зүйн перифраз. Жишээ нь *instruments of destruction = pistols*/сүйтгэж сөнөөх зүйл = буу/; *the most pardonable of human weakness = love* /ядарсан нэгнийг өршөөн тэтгэх = хайр/
- Figurative буюу утга шилжсэн перифраз: Жишээ нь *in disgrace with fortune and men's eyes = in misfortune* /эрчүүдийн өмнө гутамшиг болох = азгүйтэх/; *to tie the knot = to marry* / уяж зангидуулах = гэрлэх, хурим хийх/

Уран зохиол болон яруу найргийн орчуулгад коннотаци, перифразийг орчуулахдаа үгсийн сангийн хувиргал хийж орчуулах нь илүү тохиромжтой юм. Орчуулгын сэтгэц хэл шинжлэлийн үүднээс эхлээд орчуулагч тухайн бичвэр дэх коннотаци, перифразийн далд утгыг ойлгож, дотроо кодлоод дараа нь орчуулгын текст болгон буулгахдаа эх хэлний нэгжийн зөв хувилбарыг сонгож орчуулгын бичвэр болгон буулгана.

Алтай овог хэлний Монгол хэл, Энэтхэг –Европ бүлгийн Орос, Англи хэлнүүд хэл зүйн өөр бүтэцтэй, соёлын асар их ялгаатай учир ижил төстэй хоёр зүйлийн нэгийнх нэр нөгөөд шилжсэн метафор утга, коннотаци, перифраз утга их тааралддаг бөгөөд эдгээрийг Монгол уншигчдад ойлгомжтой зөв орчуулахын тулд зайлшгүй үгийн сангийн хувиргал хийх шаардлагатай болдог.

Г.Аким үгсийн сангийн хувиргалыг: Харь хэлний үгийн хам үгтэйгээ хамтран гаргаж байгаа утгыг олж, толинд зааснаас өөр тохирлыг оноохдоо хэрэглэдэг логик-сэтгэхүйн аргыг үгийн сангийн хувиргал гэж тодорхойлсон. Үгийн сангийн хувиргалыг Оросын орчуулгын онолч Рецкер:

1. Утга нарийвчлах
2. Утга ерөнхийлөх
3. Утгыг өрнүүлэх
4. Бүхлээр нь өөрчлөх
5. Нөхөх гэж ангилсан байдаг¹⁸⁷

Эх зохиол дахь коннотаци, перифразийг орчуулах нь:

Америкийн зохиолч Чарльз Диккенсийн “Дэвид Копперфилд” романыг 1959 онд Орос хэлнээс Монгол хэлэнд буулгасан. Энэ зохиолд орчуулагч зарим нэг коннотаци агуулсан үгийн далд утгыг хувиргал хийлгүй шууд орчуулсан байдаг ч Монгол уншигчид энэ гайхамшигт романаас тухайн үеийн Английн нийгэм, язгууртан болон энгийн ардын амьдралын зовлон жаргал, соёлын онцлогийг бүрэн ойлгох боломжтой бүтээл юм.

Коннотаци, перифраз агуулсан жишээ:

¹⁸⁷Г.Аким. Орчуулгад үгсийн сангийн хувирлыг хэрэглэх нь. Шинжлэх ухаан амьдрал 1980.

1. ...Contented? He answered, merrily, "I never contented except with your freshness, my *gentle Daisy*. (elliptical sentence)

Сэтгэл ханах гэнээ гэж Стийрфорт хөгжилтэйгөөр давтаж хэлээд яагаад чи тэгж бодов доо. Надад хонгор сэтгэлтэй замбага чиний минь гэнэхэн сайхан аашнаас өөр сэтгэл ханамжтай юу ч байдаггүй. /22-р бүлэг. Хуучин нөхөд шинэ байдалд /

Энэ өгүүлбэрийн Монгол орчуулгыг уншихад насанд хүрсэн хоёр эр хүний бие биедээ хандсан нөхөрсөг яриа гэхээсээ, нэгэн эр хүний эмэгтэй хүнд хандаж ярьсан хайр сэтгэлийн яриа шиг ойлгогдохоор байна.

Харин зохиолч Англи хэлний *Gentle* гэдэг үгийг сонгож авсан энэ үг хэдий “**уян зөөлөн**” гэдэг шууд утгатай ч хүний зан чанар, онцлог заасан тэмдэг нэрийн үүргээр орохдоо эр хүйс рүү илүү хандсан коннотаци утга агуулдаг нь **Gentle** –гэдэг үгийн толь бичгийн тайлбараас харагддаг.

Gentle. I – aristocratic, gentlemanly, ladylike,

Gentle. II - belonging to or characteristic of the nobility or aristocracy; "an aristocratic family"; "aristocratic Bostonians"; "aristocratic government"; "a blue family"; "blue blood"; "the blue-blooded aristocracy"; "of gentle blood"; "patrician landholders of the American South"; "aristocratic bearing"; "aristocratic features"; "patrician tastes"

Англи эхэд байгаа **Daisy** гэдэг үгийг **Замбага** гэж шууд утгаар орчуулсан байгаа нь ярилцагч хүнийг бүр эмэгтэйлэг болгон дүрсэлжээ. Гэтэл эх зохиолд ярилцагч хүн нь зохиолын гол баатар насанд хүрсэн залуу язгууртан эр Дэвид юм.

Сонгодог уран зохиолын өвөрмөц найруулгад зохиогч перифраз утгаар Дэвидийг тэр үеийн Английн язгууртан хөвгүүдийн нийтлэг төрх болсон цайвар царай, цэвэрхэн төрх, хар ажилд эвдрээгүй биеийн танхил байдлыг дүрсэлж **Gentle daisy** гэдэг үгийг сонгосон байгаа нь Англи хүмүүст царайлаг язгууртан эрийг дүрсэлж чадаж байгаа бол орчуулгыг уншаад Монгол хүн ингэж ойлгох боломжгүй юм.

Замбага гэдэг нь бурханд тахил өргөдөг жижигхэн цагаан дэлбээтэй мөнх ногоон навчтай цэцэг юм. Монгол хүний сэтгэхүйд эр хүнийг цэцэгтэй зүйрлэх зүйрлэл огт байхгүй тул энэ өгүүлбэрт үгсийн сангийн үг солих, орхих гэдэг орчуулгын хувиргалын аргыг хэрэглэж, **Gentle daisy** гэдэг үгийг **эрхэмсэг залуу найз минь** гэж шилжих утгаар нь сольж, **Your** (possessive pronoun) гэдэг хамаатуулах төлөөний үгийг **гэнэхэн сайхан аашнаас чинь** гэж найруулсан бол утга дүйцсэн орчуулга болох байсан болов уу гэж үзэж байна.

2. "...I hope Butterbur sends this promptly. A worthy man, but his memory is like a **lumber-room**; thing wanted always buried. If he forgets, I shall roast him.Fare well!" (J.R.R. Tolkien. The fellowship of the ring. The Strider.)

“...Найдаж байна шүү. Лавр энэ захиаг хурдан илгээнэ. Хүн шиг л хүн, даанч ой той гэж **шүүрэн шанага даа**. Мартвал тэрнээр шөл хийнэ. Аз хийморь тань бадраг!” (Ж.Р.Р. Толкейн. Бөгжний ахан дүүс. Тэнэмэл. Ж.Оюунцэцэг)

Энэ өгүүлбэрт **lumber room** гэдэг нь **модон амбаар, пин** гэсэн шууд утгатай *хэрэггүй зүйл* гэсэн перифраз илэрсэн хэлц юм, **thing wanted always burreid...** гэсэн контекст утгыг нь орчуулбал **хог новш дүүрсэн** гэсэн утгатай. Орчуулагч эдгээр хэлцийн утгыг ерөнхийлж **шүүрэн шанага** гэдэг үгийг сонгосон нь туйлын мартамхай гэсэн далд утгыг Монгол хүний сэтгэхүйд шууд буухаар орчуулга болсон байна. Хэрэв утга ерөнхийлөх хувиргал хийлгүй шууд үгчлэн орчуулсан бол тэр хүний мартамхайг нэлээд тойруу, ойлгомж муутайгаар илэрхийлэх байсан.

“**Farewell!**” гэдэг үг аян замын үдэлтийн “Сайн яваарай! Баяртай!” гэсэн утгатай. Орчуулагч энд үгсийн сангийн хувиргалын *бүхлээр нь өөрчлөх арга* хэрэглэн Монголчуудын сайн мэдэх **Аз хийморь тань бадраг!** гэсэн үдэлтийн үгээр сольсон нь аюулыг сөрж аз туршин яваа аянчдад яг тохирох үг юм. Эх бичвэрийн хам утгаас нь харахад энэ тохиолдолд зүгээр нэг “Сайн яваарай! Баяртай!” гэдэг үг утга зүйн хувьд хүчгүйдэх юм.

Энэ бүгдээс харахад аливаа ард түмний хэл соёлыг дамжуулж нэг хэлнээс нөгөө хэлрүү орчуулга хийнэ гэдэг асар их хөдөлмөр зүтгэл юм.

“Хүний тархинд болж байгаа процесс аль ч ард түмэнд адилхан байдаг. Түүнийг илэрхийлэх арга нь хэл юм. Нэгэнт сэтгэхүйн процесс адил байхад нэг хэлний ухагдахуунд тохирох ухагдахуун нөгөө хэлэнд байх боломжтой. Харин энэ тохироог олж зөв хувиргал хийх нь орчуулагчийн ур чадвар” гэж эрдэмтэн Г.Аким гуайн бичсэнтэй бид санал нэг байна.

Дүгнэлт

Коннотаци, перифраз утга нь аливаа хэлэнд түгээмэл илэрдэг, бодит юмс үзэгдлийг заадаг хэдий ч өөр хэлэнд орчуулж дамжуулахад нэлээд төвөгтэй утга юм. Тогтсон утга байгаа боловч тодорхой денотат байхгүй хийсвэр үгс ч бас байдаг *аврал, өршөөл, гэгээрэл, буян* гэх үгсэд *бурхан* гэх коннотаци утга агуулагддаг ч бурхан нь байхгүй хийсвэр зүйл. Коннотаци, перифраз утгын орчуулга нь нэг талаараа зөвхөн тухайн хэлээр яригч ард түмэн, тухайн соёлд хамрагчдын хувьд ойлгодог өвөрмөц соёлын нэг хэлбэр иймээс үүнийг орчуулах нь соёлын орчуулга болдог. Хоёр өөр хэл, соёлтой ард түмний хэл, соёл хоорондын орчуулгыг сайн хийхийн тулд орчуулагч тухайн хэлээр яригч ард түмний түүх соёл, хэл хоорондын харилцааны онцлог талуудыг сайтар судласан байх шаардлагатай. Ялангуяа уран зохиол яруу найрагт коннотаци, перифраз утга агуулсан соёлын онцлог ялгаа их байдгийг анхаарч орчуулга хийх нь зүйтэй юм.

Abstract

This research paper seeks to explain how the method of lexical transformation can be employed to maintain the stylistic attributes of an original literary work when translating it.

Despite the changing literary environment, classical literature remains integral to a well-rounded and comprehensive education, even if this literature is not always available in people's native tongue. Translating classical literature will allow people to more directly benefit from these classics.

However, there are several challenges involved in translation, due to the fact that languages most commonly used in classical literature, including English and Russian, are in the proto-Indo-European language family, while Mongolian is in an Altaic Asiatic language family. As such aspects like lexical correspondence, idioms, and syntax don't always directly correspond; lexical transformation must be applied properly to ensure connotations are maintained and the essences of the ideas are properly communicated. Periphrasis is widely used in the literary and every day communication. Periphrasis as a stylistic device is a new, genuine nomination of an object, a process which realizes the power of language to coin new names for objects by disclosing some quality of the object.

Ном зүй

Монгол хэлээр:

- Аким. Г (1984) “**Орчуулгын санг уудлахад**”, Уб.,
Бадамдорж.Д (2006) “**Монгол хэлний үгийн сангийн утгазүй**”, Адмон,
Уб.,
Хэл шинжлэл “Соёмбо” нэвтэрхий толь
Базаррагчаа, Мөнхжаргал, (2000) “**Монгол хэл**”, БСШУ-ны Яам, Уб.,
Бат-Ирээдүй.Ж (2008) “**Монгол хэлц үг, хэллэгийн утга хэрэглээ**”, Мон-
Эдьюкэшин Пресс. Уб.,
Я. Цэвэл, (1966) “Монгол хэлний товч тайлбар толь”, УБ
Ж.Оюунцэцэг (2009) “Бөгжний эзэн” Уб.,
Ш.Очирбат, (1959) “Дэвид Кооперфельд” Уб.,

Англи хэлээр.

- Claire Kramsch (1998) “**Pocket Oxford dictionary**” Oxford University Press,
J.R.R. Tolkien (2002) “Lord of ring, Fellow of ring” US. Boston
Roget's 21st century thesaurus dictionary
Charles Dickens.(1850) “David Copperfield.”